



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон түүнийг дагалдсан бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Лүндээжанцан - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Ж.Батзандан - Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат - Улсын Их Хурлын гишүүн
Р.Гончигдорж - Улсын Их Хурлын гишүүн
Ө.Энхтүвшин - Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Н.Мөнхбат - Засгийн газрын хэрэг эрхлэх газрын референт


Ц.Банзрагч - Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ойн хамгаалал, ойжуулалтын зохицуулалтын хэлтсийн дарга

Б.Цэдэнсамба - Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Х.Авирмэд - Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга

С.Золзаяа	-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн даатгалын албаны дарга
Ч.Нямсайхан	-Зам тээврийн яамны Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга
Ц.Ганзориг	-Хууль зүйн яамны Дотоод хэргийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн
Г.Наранчулуун	-Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
Т.Дуламдорж Б.Мягмаржав	-Онцгой байдлын ерөнхий газрын дарга -Цөмийн энергийн газрын Хуулийн хэлтсийн дарга
С.Баатарсүрэн	-Гамшиг, гал түймрээс хамгаалах Монголын нийгэмлэгийн зөвлөх
Э.Түвшинжаргал Г.Нямдэлгэр Б.Хонгорзул	-Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх -Хууль зүйн байнгын хорооны зөвлөх -Хууль зүйн байнгын хорооны референт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



ТҮВДЭНДОРЖ